




ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



2015 он

АГУУЛГА:

1. Судалгааны агуулга, зорилт
2. Аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил
3. Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал
4. Үйлдвэрлэл салбараар
5. Үйлдвэрлэл улсын түвшний харьцуулалт
6. Аймгийн нийт үйлдвэрлэл баруун бүсийн түвшинд харьцуулалт
7. Нийт үйлдвэрлэл биет хэмжээгээр харьцуулалт
8. Барилгын салбарын танилцуулга
9. Үйлчилгээний салбар
10. Дүгнэлт
11. Ашигласан материал

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтүүдээр нэгдсэн танилцуулга бэлдэж тэдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлж орон нутгийн удирдлагыг дэлгэрэнгүй мэдээллээр хангахад чиглэнэ.

Нэг. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

А. Аймгийн аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил

Аж үйлдвэрийн салбарын үүсэл хөгжил.

Аймгийн аж үйлдвэрийн салбар нь анх 1925 онд *Архи худалдаалахсангийн хороо* нэртэйгээр байгуулагдсан хүнсний үйлдвэрээр манай аймгийн аж үйлдвэрийн салбарын суурь тавигдсан билээ. 1938 онд хүн амын өргөн хэрэглээний хувцас үйлдвэрлэдэг гар үйлдвэрлэлийн хоршоодын холбоо, 1945 онд хэвлэлийн үйлдвэр, 1963 онд Тосонцэнгэлийн мод боловсруулах комбинат, 1966 онд авто тээврийн 20-р баазын харъяанд байсан дизель станц бие даасан эрчим хүчний үйлдвэр болсон ба мөн онд ойг нөхөн сэргээх, хамгаалах үүрэг бүхий ойн аж ахуй ажиллажээ. 1968 онд жилдээ 150 автомашин, 120 хөдөлгүүрт их засвар хийх хүчин чадалтай авто засварын газар, 1972 онд барилгын материалын үйлдвэр болон жилдээ 10000 тн багсармал тэжээлийн үйлдвэр Тэс сумд ашиглалтанд орж, 1983 онд жилдээ 1500 тн малын мах үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадалтай мах боловсруулах үйлдвэр, 1984 онд жилдээ 75мян,г,кал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай төвлөрсөн уурын зуух, жилдээ 500тн угаалгын нунтаг үйлдвэрлэх хүчин чадалтай угаалгын нунтгийн үйлдвэр Дөрвөлжин сумын нутаг Хомын талд ашиглалтанд орж байжээ. Тухайн үед аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэр, сумдын дизель станц, халаалтын зуухнуудыг нэгтгэн жилдээ 16.6 сая. квт/цаг цахилгаан, 75 мян.г.кал дулаан үйлдвэрлэж байв.1983-1986 онд Тосонцэнгэлийн мод боловсруулах комбинатын өргөтгөл, шинэчлэлт хийгдэж, тус комбинатын дулаан үйлдвэрлэл жилдээ 32 мян.г.кал дулаан үйлдвэрлэж байв. 1985 онд барилгын материалын үйлдвэрийн, 1986 онд хүнсний үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлт хийгдэж хэвлэх үйлдвэрийн барилга баригдаж ашиглалтанд орсон байна.Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр тухайн үеийн үйлдвэрлэл зогсонги байдалтай байсан боловч 90 оны дунд үеэс орчин үеийн техник, технонологи нэвтэрж үйлдвэрийн салбар сэргэж байна. Цахилгаан үйлдвэрлэлийн хувьд 24 сум төвлөрсөн системд холбогдож Тайшир, Идэр, Богд, Хүнгүй, Галуутайн голын усан станцууд баригдан ашиглалтанд орсоноор жижиг дунд үйлдвэрлэл хөгжих таатай нөхцөл бүрдэж, жилд дунджаар 1500 тн ноос

Завхан аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар

угааж, 20000 кв.м эсгий үйлдвэрлэх үйлдвэр, мах боловсруулах 2 үйлдвэр, гурилын үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орсоноор 2014 оны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 11 тэрбум 628.4 сая төгрөг болж 2010 оноос 14.1 хувиар буюу 1 тэрбум 438.7 сая төгрөгөөр өсч, өнгөрсөн оноос 8.4 хувиар буюу 904.6 сая төгрөгөөр өссөн нь боловсруулах үйлдвэрлэлийн нэр төрлийн бүтээгдэхүүнүүд 8.7-637.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

В. Аймгийн үйлдвэрлэл

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, /салбараар оны үнээр/

/ сая,төг, million. tog /

Аж үйлдвэрийн салбар		үйлдвэрлэл					Үүнээс		
		2010	2011	2012	2013	2014	ТӨУУГ	Хувийн хэвшил	
Нийт дүн		10189.7	11665.4	11648.5	10723.8	11628.4	4233.8	7394.6	
Боловсруулах үйлдвэр		1770.0	2833.2	2567.4	3917.8	4890.6	0.0	4890.6	
Үүнээс	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	1261.9	1419.4	1689.6	2086.5	2290.1	0	2290.1	
	Үүнээс	Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.7	6.6	17.5	34.3	6.7		6.7
		Нарийн боов, талх, чихэр үйлдвэрлэл	918.3	1114.9	1412.6	1750.6	1948.8		1948.8
		Хиам	18.6	1.6	0.0	1.7	10.4		10.4
		Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	301.7	272.9	238.9	247.6	277.7		277.7
		Иоджуулсан давс	14.6	23.4	20.6	52.3	46.5		46.5
	Хувцас үйлдвэрлэл	252.0	306.0	408.5	598.7	1236.0		1236.0	
	Модон эдлэл үйлдвэрлэл	182.8	1003.6	427.8	576.3	1023.6		1023.6	
	Блок, тоосго	0.0	68	162.9	328.0	258.5		258.5	
	Гурил үйлдвэрлэл	0	0	399	141.8	17.7		17.7	
	Эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэл	8.6	2.8	1.6	136.8	26.2		26.2	
	Бусад /төмөр/	64.7	33.4	41.5	49.7	38.5		38.5	
	Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж		8419.7	8832.2	9081.1	6806.0	6737.8	4233.8	2504
Үүнээс	Цахилгаан үйлдвэрлэл	6264.9	6672.9	6704.6	4228.2	3635.6	3635.6		
	Дулаан үйлдвэрлэл	1897.1	1880.7	2081.1	2179.3	2757.3	253.3	2504	
	Усан хангамж	257.7	278.6	295.4	398.5	344.9	344.9		


Аймгийн 2014 оны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 11 тэрбум 628.4 сая төгрөг болж 2010 оноос 14.1 хувиар буюу 1 тэрбум 438.7 сая төгрөгөөр өсч, өнгөрсөн оноос 8.4 хувиар буюу 904.6 сая төгрөгөөр өссөн нь боловсруулах үйлдвэрлэлийн нэр төрлийн бүтээгдэхүүнүүд 8.7-637.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.


Тайлант хугацаанд улсын мэдээнд орсоноор аймгийн уул уурхайн салбарт алт 0.3 тн буюу 17.7 тэр бум төгрөгийн олборлолт хийгдээд байна.

Энэ онд хүнсний бүтээгдэхүүн, хувцас, модон эдлэл, барилгын ханын материал, эсгий, эсгий эдлэл, зэрэг бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл өсч, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн байна. Шинээр сүлжмэл, нэхмэл, суран эдлэл, бэлэг дурсгалын зүйл, эсгий, эсгий эдлэл, гэрийн мод, барилгын ханын материал, гурил зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 57.9 хувийг, хүнсний үйлдвэрлэл 19.7 хувь, хувцас үйлдвэрлэл 10.6 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 8.8 хувь, барилгын ханын материал 2.2 хувь, гурил үйлдвэрлэл 0.2 хувь, эсгий, эсгий эдлэл 0.2 хувь, бусад үйлдвэрлэл 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжид нийт 968 ажиллагсад ажиллан, нийт үйлдвэрлэлд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл 63.6 хувийг эзлэж байна.







Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтцийг авч үзвэл:

	Дүнд эзлэх хувь		Өөрчлөлт/өсөлт+ бууралт-/
	2013	2014	
Хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэл	19.5	19.7	+0.2
Хувцас үйлдвэрлэл	5.6	10.6	+5.0
Мод модон эдлэл үйлдвэрлэл	5.4	8.8	+3.4
Ханын материал үйлдвэрлэл	3.1	2.2	-0.9
Бусад үйлдвэрлэл	6.0	0.7	-5.3

Хүнсний салбарын үйлдвэрлэлтийн бүтцийг авч үзвэл:





2013 оноос хүнсний салбарын нийт үйлдвэрлэлт 9.8 хувь буюу 203.6 сая төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 2005 оноос хойшхи өсөлт бууралтыг диаграммаар үзүүлбэл:



Сүүлийн 10 жилээр нийт үйлдвэрлэлтийг авч үзэхэд жил тутам өссөн байдалтай байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2005-2011 он хүртэлх жигд өсөлттэй байгаа бөгөөд 2012 оноос бууралттай харагдаж байгаа нь төвлөрсөн эрчим хүчний системд холбогдож, орон нутагт цахилгаан үйлдвэрлэж байсан өндөр өртөгтэй дизель станцийн үйлдвэрлэл багассанаар улсаас авч байсан татаац зардлын хэмжээ буурч байгаагаас бууралт харагдаж байгаа хэдий ч нь орон нутаг дахь бусад жижиг дунд үйлдвэрлэлийн цар хүрээ, дэд бүтцийн өсөлт нэмэгдэж байгаа нь нийт үйлдвэрлэлийн өсөлтөнд эерэгээр нөлөөлөх хандлага гарч байна.





Аймгийн аж үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд

Он	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оны үнэ, сая.төг	Бүтээгдэхүүн борлуулалт, оны үнэ, сая.төг	Ажиллагсдын тоо	Хөдөлмөрийн бүтээмж, саятөг	Нэг өдрийн үйлдвэрлэлт, сая.төг	Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, мян.төг
2005	5505.7	5464.5	775	7.1	22.0	70.0
2006	5588.5	5578.6	688	8.1	22.4	70.7
2007	6415.2	6390.4	780	8.2	25.7	80.7
2008	7682.5	7670.4	724	10.6	30.7	100.3
2009	8689.6	8653.2	735	11.8	34.8	116.0
2010	10189.7	10181.8	793	12.8	40.8	141.8
2011	11594.6	11546.2	868	13.3	46.0	163.8
2012	11648.5	11646.4	870	13.4	46.2	167.1
2013	10723.8	10642.7	902	11.9	42.6	153.6
2014	11628.4	11628.4	968	12.0	44.6	167.1

Нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2005 онд 70.0 мянган төгрөг байсан бол 2014 оны байдлаар 167.1 мян төгрөг буюу 2.4 дахин өссөн байгаа нь жил бүр тогтмол өсөлттэй байсныг харуулж байна. Аймгийн аж үйлдвэрийн салбарт 968 ажиллагсад ажиллаж нэг ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 12.0 сая төгрөг,

Завхан аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар

жилд дунджаар 44.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын тоо аймгийн нийт ажиллагсдын 2.4 хувийг эзэлж байна.

Завхан аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг баруун бүсийн аймгуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээтэй харьцуулан судаллаа. Мөн аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн улсын үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээг авч үзлээ.

Аймгийн аж үйлдвэрийн өнөөгийн байдал

	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /оны үнээр, тэрбум.төг/		
	Улсын дүн	Аймгийн дүн	Улсын дүнд эзлэх хувь
2004	1317.3	4.9	0.4
2005	1465.5	5.5	0.4
2006	1598.9	5.6	0.4
2007	1753.5	6.4	0.4
2008	2928.3	7.7	0.3
2009	3099.9	8.7	0.3
2010	4468.2	10.2	0.2
2011	5626.7	11.6	0.2
2012	6058.0	11.6	0.2
2013	6456.6	10.7	0.2
2014	9299.6	11.6	0.1

Баруун бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт /сая,төг/

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Завхан	4918.1	5505.7	5588.5	6415.2	7682.5	8689.6	10189.7	11665.4	11648.5	10723.8	11628.4
Говь-Алтай	2855.1	2690.5	2900.0	3478.1	6537.7	5578.0	11253.3	13870.9	12096.4	13938.4	10818.4
Баян-өлгий	2148.3	2786.6	4004.2	5204.9	8337	8024.5	8606.8	11284.0	11312.4	7445.0	12220.1
Ховд	1413.8	1687.4	1827.7	1696.0	2325.7	3852.1	4019.0	5710.2	4568.3	5533.6	5622.2
Увс	2337.7	2073.3	2771.8	3204.2	3989.1	5031.9	5784.8	12468.6	7661.6	8473.7	8955.6

2014 онд аймгийн аж үйлдвэрийн салбар баруун бүсийн нийт бүтээгдэхүүний 23.6 хувийг үйлдвэрлэсэн байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл /биет хэмжээгээр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл									
		2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл	мян.квт.ц	10816	11491	12073	12693	13308.9	15685	18567.5	19257.9	12482.2	6021.4
Дулааны үйлдвэрлэл	мян.г.кл	100.3	96.7	124.5	115.9	161.8	166.1	163.7	182.2	190.8	241.5
Савхин гутал	хос	190	70	709	421	436	980	2197	2225	1839	1892
Хүүхдийн гутал	хос	271	57	812	30	0	104	228	336	564	357
Монгол гутал	хос	203	94	857	213	447	950	586	893	1178	1183
Монгол дээл	ширхэг	781	562	1786	2426	1657	1880	3926	5441	7613	12521
Талх	тонн	317	114.6	132.2	106.3	238.9	264.6	369.6	482.6	749.8	459.8
Нарийн боов	тонн	57.2	38.3	84.6	89.9	143.9	232	366.4	463.1	888.3	626.9
Чихэр	тонн	6.5	3.9	5.1	3.9	2.2	3.8	5.6	7.8	3.7	11.1
Архи дарс	мян.л	165.2	148.3	143.9	74.6	54.4	60.5	48.6	42.8	53	39.4
Ундаа	мян.л	84.1	18	56.6	25.7	2.4	10.9	21.2	37.1	15.9	16.2
Хиам	тонн	6.4	3	29.5	2.2	5.3	4.4	0.4	-	0.3	1.8
Ус борлуулалт	мян.куб.м	109.5	148.8	147.2	143.1	142.7	138.7	149.4	160.6	200	172.2

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2010 онтой харьцуулахад нийт үйлдвэрлэл 14.1 хувь буюу 1438.7 мянган төгрөгөөр өссөн байна. Эдгээр өсөлт, бууралтанд үйлдвэрийн нэгжийн үнийн өөрчлөлт, бүтээгдэхүүний биет хэмжээний өөрчлөлт суурь онтой харьцуулахад хэрхэн нөлөөлсөнийг Талх, нарийн боов, чихэрийн үйлдвэрлэлийг статистикийн индексийн шинжилгээний аргаар тооцож үзлээ:

Үйлдвэрлэсэн Талх, нарийн боов, чихэрийн нэгжийн үнийн өөрчлөлтийн нөлөөлөл:

$$I_p = \frac{\sum Q_1 P_1}{\sum Q_1 P_0} = \frac{1948.8}{918.3} \approx 212.2 \text{ хувиар буюу } 1.2 \text{ дахин үйлдвэрийн үнэ өссөн нь}$$

үйлдвэрлэлтийг 1030.5 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

2. Биет хэмжээний өөрчлөлтийн нөлөөлөл:

$$I_q = \frac{\sum Q_1 P_0}{\sum Q_0 P_0} = \frac{1097.8}{500.4} \approx 219.4 \text{ хувиар буюу } 2.2 \text{ дахин өссөн нь үйлдвэрлэлийн биет}$$

хэмжээг 597,4 мян.кг өсөхөд нөлөөлсөн байна.


Хоёр. Барилгын салбар

Барилга угсралт, их засварын ажил 2014 онд 19 тэрбум 14.8 сая төгрөг болж өнгөрсөн оноос 30.8 хувиар буюу 5.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ онд гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг салбараар авч үзвэл: Сургууль, цэцэрлэг, соёл биеийн тамирын объектын бүтээн байгуулалтын ажилд 7 тэрбум 983.1 сая төгрөг, зам гүүр бусад зам талбайн ажилд 5 тэрбум 692.1 сая төгрөг, худалдаа үйлчилгээний барилга байгууламжид 179.5 сая төгрөг, эмнэлэгийн барилгын ажилд 861.1 сая төгрөг, конторын барилгын ажилд 2 тэрбум 84.5 сая төгрөг, орон сууцны бус барилгын их засвар, бусад барилгын ажилд 807.8 сая төгрөг, эрчим хүчгий барилгад 727.5 сая төгрөг, инженерийн барилга байгууламж, их засварын ажилд 729.2 сая төгрөг, бусад барилга бүтээн байгуулалтын ажилд 50 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.



	2011	2012	2013	2014
Объектын тоо	20	14	12	41



2014 ОНД АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН БАРИЛГА ОБЕКТ

№	Объектын нэр	Барилгын төрөл	Хүчин чадал	Давхар	Талбайн хэмжээ	Барьж дууссан огноо
1	Завхан аймаг Улиастай сум Дэвшил сургуулийн Б байрны засвар	Орон сууцны бус барилгын их засвар	160 суудал	1	576	8/25/2014
2	Дэвшил сургуулийн технологийн байрны засвар	Орон сууцны бус барилгын их засвар	80 м2	0	80	10/27/2014
3	Отгон сумын Бадрал багийн худгийн засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	4	7/28/2014
4	Цагаанчулуут сумын Арц багийн Шивээтийн өврийн шинэ худаг	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	3.2	10/17/2014
5	Завхан аймгийн Шилүүстэй сумын Хөгжил багийн худаг	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	3.2	10/15/2014
6	Шилүүстэй сумын Хөгжил багийн худаг Дүгжүүрийн арын худаг	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	4	10/15/2014
7	Эрдэнэхайрхан сумын Алтан багийн шинээр гаргасан худгийн ажил	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	4	10/15/2014
8	Яруу сумын Зүйл багийн худаг засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	4	8/15/2014
9	Яруу сумын Зүйл багийн зүйлийн адгийн худаг засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	4	8/15/2014
10	Завханмандал сумын Мандал багийн Сэвэстийн худгийн засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	2 м3	0	3.2	12/4/2014
11	Завхан аймаг Завханмандал сум хүн эмнэлэгийн гүнийн худаг	Бусад (бусад зам, талбайн ажил)	2 м3	0	3.2	9/1/2014
12	Завхан аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн конторын барилга	Конторын	510 м2	2	510	12/9/2014
13	Улиастай сум 5-р цэцэрлэгийн барилгын засвар	Орон сууцны бус барилгын их засвар	600 м2	2	600	10/6/2014
14	Завхан аймаг Асгат сум цагдаагийн кубоны барилга	Конторын	84 м2	1	84	9/10/2014
15	Мэдээлэл холбоо сүлжээний барилгын засвар	Орон сууцны бус барилгын их засвар	120 м2	2	120	10/20/2014
16	ХААН банкны их засварын ажил	Орон сууцны бус барилгын их засвар	56 м2	1	56	8/20/2014
17	МСҮТ-ийн хичээлийн байрны барилга	Сургууль	80 суудал	2	2700	9/30/2014
18	Эрдэнэхайрхан сумын ХААН банкны засвар	Орон сууцны бус барилгын их засвар	80 м2	1	80	8/29/2014
19	Завхан аймаг Сонгино сум эрчим хүчний 04 шугамын ажил	Эрчим хүчний	3000 уртааш м	0	3000	9/2/2014
20	Улиастай сум Уулзвар замын гэрэлтүүлэгийн ажил	Эрчим хүчний	3960 уртааш м	0	3960	8/25/2014

Завхан аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар

№	Объектын нэр	Барилгын төрөл	Хүчин чадал	Давхар	Талбайн хэмжээ	Барьж дууссан огноо
21	Явуугийн цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлгийг сайжруулах	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	200 м	0	200	12/25/2014
22	Идэр сум 240 хүүхдийн сургуулийн хичээлийн байрны засвар	Орон сууцны бус барилгын их засвар	800 м2	1	800	8/20/2014
23	Улиастай сум Товцог багийн явган хүний зам, замын гэрэлтүүлэг	Бусад (бусад зам, талбайн ажил)	3.5 км	0	625000	9/10/2014
24	Завхан аймаг Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн барилгын засвар	Орон сууцны бус барилгын их засвар	900 м2	2	900	8/4/2014
25	МУИС-ын Завхан сургуулийн заалны засварын ажил	Орон сууцны бус барилгын их засвар	324 м2	0	324	10/28/2014
26	Чигэстэй багийн иргэдийн хөгжлийн төв	Конторын	352 м2	2	352	12/17/2014
27	Улиастай сумын 4-р 10 жилийн цэвэр ус цооногийн барилга	Орон сууцны бус бусад барилга	76 м2	0	76	9/1/2014
28	Хүний хөгжлийн төвийн барилга	Конторын	320 м2	2	320	12/20/2014
29	Яруу сумын соёлын төвийн барилгын засвар	Орон сууцны бус бусад барилга	200 суудал	1	720	8/19/2014
30	Отгон сумын биеийн тамир спортын цогцолбор	Спорт, биеийн тамир	250 суудал	1	900	7/11/2014
31	Эрдэнэт хот Баян-өндөр сум Урт гол баг гэрэлтүүлгийн ажил	Эрчим хүчний	2300 уртааш м	0	2300	8/22/2014
32	Эрдэнэт хот Баян-өндөр сум Булагт баг гэрэлтүүлгийн ажил	Эрчим хүчний	2400 уртааш м	0	2400	10/15/2014
33	Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын 10 ортой эмнэлэгийн барилга	Эмнэлэг	10 ор	2	650	10/22/2014
34	Завхан аймаг Тосонцэнгэл сум МСҮТ-ийн барилга	Сургууль	320 суудал	2	812	10/20/2014
35	Улиастай сар хайрхан авто замын засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	80 км	0	80	12/25/2014
36	Нөмрөг Сонгино Улаангомьн авто замын засвар	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	40 км	0	40	12/25/2014
37	Мөрөн-Улиастай зас засвар, арчилгаа	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	90 км	0	630000	2/28/2014
38	Тосонцэнгэл сум Хас банкны барилга	Конторын	440 м2	1	440	9/25/2014
39	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 100 ортой цэцэрлэгийн барилга	Цэцэрлэг	100 хүүхэд	2	648	11/14/2014
40	Завхан аймаг Тосонцэнгэл сумын МСҮТ-ийн 320 хүүхдийн хичээлийн байр	Сургууль	320 суудал	2	812	10/20/2014
41	Завхан аймаг Тэс сум халуун усны барилга	Худалдаа, үйлчилгээний	75 м2	1	75	8/14/2014

Дүгнэлт

Завхан аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр тогтмол өсөлттэй байгаа ба 2005 онд нийт үйлдвэрлэлт 5505.7 сая төгрөг байсан бол 2014 онд нийт үйлдвэрлэл 11628.4 сая төгрөгт хүрч үйлдвэрлэл 2.1 дахин буюу 6122.7 сая төгрөгөөр өссөн байна. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээний тогтмол өсөлтөнд төрөөс явуулж буй жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг зэрэг нь нөлөөлж байна.

Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 57.9 хувийг, хүнсний үйлдвэрлэл 19.7 хувь, хувцас үйлдвэрлэл 10.6 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 8.8 хувь, барилгын ханын материал 2.2 хувь, гурил үйлдвэрлэл 0.2 хувь, эсгий, эсгий эдлэл 0.2 хувь, бусад үйлдвэрлэл 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжид нийт 968 ажиллагсад ажиллан, нийт үйлдвэрлэлд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл 63.6 хувийг эзлэж байна. Хүнсний салбарын үйлдвэрлэл болон барилгын ханын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь илүү өсөлттэй байгаа нь нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтөнд эерэгээр нөлөөлж байна. Бусад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд жигд өсөлттэй байна.

Аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүдийг авч үзэхэд нэг ажилтны хөдөлмөрийн бүтээмж, нэг өдрийн үйлдвэрлэлтийн хэмжээ, нэг хүнд ногдох үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ зэрэг жил бүр нийт үйлдвэрлэлийн хэмжээний өсөлтийг даган жигд өсөж байна.

Цаашид үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг улам хурдацтай нэмэгдүүлэх, хангахад жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн болон тоног төхөөрөмж бусад хөнгөлөлт, эх үүсвэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд түүнд нөлөөлөх гол хүчин зүйл болох замын асуудлыг цогц хэлбэрээр хурдацтай хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Манай аймгийн хувьд зах зээлээс алслагдмал, дэд бүтэцийн хөгжил сул, хүн амын нягтаршил бага байдаг зэрэг нь жижиг дунд үйлдвэрлэлийн өсөлтөнд зарим талаар нөлөөлж байна.

Барилга угсралт, их засварын ажил 2013 онд 13 тэрбум 141.5 сая төгрөг болж өнгөрсөн оноос 81.5 хувиар буюу 5.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ онд манай аймагт дараах объектууд ашиглатанд орсон байна.

Үүнд: Улиастай сумын 50 ортой төрөх эмнэлэг, Улиастай, Их-Уул, Идэр, Ургамал сумын 100 хүүхдийн цэцэрлэг, Ургамал, Яруу сумын цагдаагийн кабон, Тосонцэнгэл сумын Нутгийн захиргааны ордон, сум дундын прокурорын байр, Баянхайрхан сумын Соёлын төвийн барилга, Отгон сумын 320 хүүхдийн хичээлийн байр, Улиастай сумын төв ХААН банкны барилга зэрэг 9 тэрбум 274.3 сая төгрөгний обектууд шинээр ашиглалтанд орлоо. Мөн Улиастай, Тосонцэнгэл Алдархаан суманд нийт 37 км харзам ашиглалтанд орсон байна.

Ашигласан ном материал

1. Аймгийн нийгэм, эдийн засгийн 2004-2013 оны эмхэтгэл
2. Монгол улсын статистикийн 2004-2012 эмхэтгэлүүд
3. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эмхэтгэлүүд
4. Бусад эх сурвалж

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга Д.Оюунгэрэл

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн

мэргэжилтэн Б.Цэгмид